



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/65/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576                      Цахим хаяг: Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140                      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn  Аудитор: М.Алтантуяа Утас:99061861                      Цахим хаяг:</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөггүй болно.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	12
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail bayankhongor@audit.gov.mn

*Solo ad, d.7* № 1/204

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -и

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР СУМЫН 9 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.ЧИМЭГСАЙХАН ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005010154


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн эрхлэгч Ц.Чимэгсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.12-наас 2020.02.14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.07-ны өдрийн 01 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго: Цэцэрлэгийн үндсэн үйл ажиллагаа болох сургалтын процесст баримтлах зарчим, хүрэх үр дүн, оюун санааны ба материаллаг хэрэгцээ, нөөц бололцоог хэрхэн ашиглах болон хангах, түүнд тавигдах шаардлага, хяналт шалгалтыг ямар арга замаар сайжруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 9-р цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acoulas" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 9-р цэцэрлэг нь төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 24 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр БСУГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 277174,1 мянган төгрөгөөс тооцон 5543,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5543,5 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 296.5 мянган төгрөгөөр буюу 0.01 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	366.7	69.1	(297.6)
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	29,875.5	32,051.6	2,176.1
Үндсэн хөрөнгө	583,295.5	591,798.0	8,502.5
Хуримтлагдсан элэгдэл	(37,066.1)	(47,743.6)	(10,677.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>576,471.6</b>	<b>576,175.1</b>	<b>(296.5)</b>
Өр төлбөр	150.5	366.7	216.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	576,321.1	575,808.5	(512.7)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>576,471.6</b>	<b>576,175.1</b>	<b>(296.5)</b>

Бараа материалын данс 2176,1 мянган төгрөгөөр өссөн нь 2303,7 мянган төгрөгийн аж ахуйн материал, хүнсний материал 1619,9 мянган төгрөгөөр тус тус өсч, Бусад материал 713,5 мянга, тусгай зориулалтын материал 1034,0 төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө 8502,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хандивын хөрөнгөөр 4787,5 мянга, төсвийн хөрөнгөөр 3715,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна. Мөн өглөг 216,2 мянган төгрөгөөр өсөж, Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөр 512,7 мянган төгрөгөөр буурсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант жилд 272171,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 272160,9 мянган төгрөг зарцуулж 10,5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Батлагдсан орон тоо 17 байхаас 17 орон тойгоор ажилласан.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар дараах 4408,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1453,9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2954,1 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлыг зарцуулахдаа нэг хүүхдэд ногдох дундаж нормативыг хэтрүүлэн 1453,9 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна. нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

2. Хоорондын тооцооны дансны гүйлгээг давтан шалгахад 6-р сард ХХОАТ-ын 366,6 мянган төгрөгийн өглөгийг НДШ-ийн авлага 318,7 мянга, ҮЭ-ийн авлага 47,8 мянган төгрөгийн авлагаар хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14.4.1-т “аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Санхүүгийн тайланд залруулав.

3. БСШУЯ-аас хандиваар ирсэн 2587,5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14.4.1-т “аж ахуйн бүх ажил, гүйлгээг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Санхүүгийн тайланд залруулав.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 9-р цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 125 мэдээллийг хугацаанд нь, 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	10	1	
2	Хагас жил	4	4	4	-	-
3	Улирал бүр	4	4	4		-
4	Сар бүр	4	36	33	3	-
	Тухай бүр	8	96	76	20	-
	Нийт	31	151	125	26	

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Зөрчилгүй” дүгнэлт**

Бид Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,242,150.0</b>	<b>32,120,697.0</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	366,674.00	69,108.98
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	366,674.00	69,108.98
3351	Байгууллагаас авах авлага	366,674.00	69,108.98
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,875,476.37	32,051,588.39
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,305,623.40	6,236,658.68
35110	Тусгай зориулалттай материал	7,269,623.40	6,236,658.68
35130	Эм боох материал	36,000.00	00.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,569,852.97	25,814,929.71
35410	Бичиг хэргийн материал	2,186,330.00	2,097,930.00
35420	Аж ахуйн материал	14,371,000.00	16,674,700.00
35440	Түлш, шатах тослох материал	00.01	00.00
35450	Барилгын засварын материал	141,000.00	00.00
35460	Хүнсний материал	828,655.96	2,448,565.96
35470	Бусад хангамжийн материал	5,042,867.00	4,593,733.75
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>546,229,456.46</b>	<b>544,054,436.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	546,229,456.46	544,054,436.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	472,779,456.46	470,604,436.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,024,287.00	460,024,287.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-7,727,606.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,606,101.22	23,908,601.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,665,690.24	-14,391,701.32
39207	Тавилга, аж ахуйн эд хөгшил	30,147,830.40	32,347,830.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,707,371.92	-24,931,274.98
39217	Ном	1,374,300.00	1,374,300.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	73,450,000.00	73,450,000.00
39301	Програм хангамж	693,000.00	693,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-693,000.00	-693,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	73,450,000.00	73,450,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>576,471,606.83</b>	<b>576,175,133.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>150,481.00</b>	<b>366,674.45</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	150,481.00	366,674.45
<b>413</b>	<b>Өглөг</b>	150,481.00	366,674.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	366,674.45
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	150,481.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	150,481.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>576,321,125.83</b>	<b>575,808,458.96</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	576,321,125.83	575,808,458.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	484,275,580.62	484,275,580.62
51101	Өмч: - төрийн	484,275,580.62	484,275,580.62
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-39,351,029.00	-39,863,695.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-39,351,029.00	-39,351,029.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-512,666.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,396,574.21	131,396,574.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>576,471,606.83</b>	<b>576,175,133.41</b>

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>249,676,758.20</b>	<b>276,959,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>245,065,323.40</b>	<b>230,150,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,269,623.40	4,787,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,269,623.40	4,787,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,269,623.40	4,787,500.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	237,795,700.00	225,363,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	237,795,700.00	225,363,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,611,434.80</b>	<b>46,808,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,190,874.80	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,190,874.80	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	46,808,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	46,808,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,420,560.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,420,560.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>252,362,900.28</b>	<b>277,471,666.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>252,362,900.28</b>	<b>277,471,666.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	239,625,271.11	277,370,730.03
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	127,536,813.57	156,630,412.38
210101	Үндсэн цалин	126,205,255.57	156,630,412.38
210104	Урамшуулал	1,331,558.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,603,156.56	19,954,809.25
210201	Тэтгэврийн даатгал	10,406,905.04	13,645,176.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,300,862.88	1,606,209.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,038,770.10	1,254,246.02
210204	Ажилгүйдлийн даатгал	259,692.78	313,560.76
210205	Эрүүл мэндийн даатгал	2,596,925.76	3,135,616.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,494,731.00	44,008,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,077,085.00	2,937,026.50
210302	Түлш, халаалт	33,976,750.00	34,344,277.50
210303	Цэвэр, бохир ус	6,440,896.00	6,726,896.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,336,529.99	7,696,797.98
210401	Бичиг хэрэг	2,323,432.25	2,516,500.00
210402	Тээвэр, шатахуун	217,535.49	340,000.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	394,817.25	684,825.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,745.00	2,091,775.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,883,697.97
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	37,546,240.00	36,365,290.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,600.00	78,200.00
210502	Хоол, хүнс	36,028,880.00	36,287,090.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,495,760.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	644,100.00
210604	Урсгал засвар	00.00	644,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	64,800.00	84,300.00
210702	Дотоод албан томилолт	64,800.00	84,300.00

**Баянхонгор сумын 9-р цэцрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	459,900.00	984,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	459,900.00	734,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,583,099.99	11,002,020.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	484,550.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	00.00	324,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,098,549.99	10,677,520.42
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,737,629.17	100,936.84
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,620,060.00	90,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,420,560.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,806,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	392,600.00	90,400.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	117,569.16	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,569.16	00.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.01	10,536.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.01	10,536.84
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-2,686,142.08</b>	<b>-512,666.87</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	7,366,478.34	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,815,448.34	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	551,030.00	00.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-7,366,478.34	00.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-10,052,620.42</b>	<b>-512,666.87</b>

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>242,407,134.80</b>	<b>272,171,500.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,190,874.80</b>	<b>225,363,300.00</b>
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,190,874.80	225,363,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,190,874.80	225,363,300.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>239,216,260.00</b>	<b>46,808,200.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	237,795,700.00	46,808,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	237,795,700.00	46,808,200.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,420,560.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,420,560.00	00.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>242,407,134.79</b>	<b>272,171,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>242,407,134.79</b>	<b>272,171,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>229,669,505.63</b>	<b>272,070,563.16</b>

**Баянхонгор сумын 9-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,284,255.34	156,620,163.16
210101	Үндсэн цалин	109,135,195.34	131,971,899.79
210102	Нэмэгдэл	3,784,100.00	9,688,000.00
210104	Урамшуулал	9,364,960.00	14,960,263.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,695,300.00	19,451,300.00
210201	Тэтгэврийн даатгал	14,522,300.00	13,588,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,687,800.00	1,465,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	198,100.00	1,172,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	49,600.00	293,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,237,500.00	2,931,500.00
<b>2103</b>	<b>Байрашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,494,731.00	44,008,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,077,085.00	2,937,026.50
210302	Түлш, халаалт	33,976,750.00	34,344,277.50
210303	Цэвэр, бохир ус	6,440,896.00	6,726,896.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,990,704.50	3,622,000.00
210401	Бичиг хэрэг	442,117.25	744,000.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	394,817.25	775,075.00
210404	Ном, хэвлэл	161,965.00	45,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	701,805.00	1,537,725.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	38,582,900.00	38,354,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,200.00	42,200.00
210502	Хоол, хүнс	36,649,500.00	37,907,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,890,200.00	405,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	142,000.00	6,653,600.00
210602	Тавилга	00.00	3,715,000.00
210604	Урсгал засвар	142,000.00	2,938,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	64,800.00	84,300.00
210702	Дотоод албан томилолт	64,800.00	84,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	459,900.00	984,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	459,900.00	734,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,954,914.79	2,291,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,862,914.79	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	92,000.00	2,291,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,737,629.16</b>	<b>100,936.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,620,060.00	90,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,420,560.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилдаг ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	10,806,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	392,600.00	90,400.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	117,569.16	10,536.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,569.16	10,536.84
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЦГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	410,825,580.62	00.00	-29,442,101.58	381,383,479.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	410,825,580.62	00.00	-29,442,101.58	381,383,479.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	73,450,000.00	00.00	-461,563.85	72,988,436.15
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,351,029.00	576,321,125.83
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,351,029.00	576,321,125.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,351,029.00	576,321,125.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-512,666.87	-512,666.87
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	484,275,580.62	131,396,574.21	-39,863,695.87	575,808,458.96

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	272,171,500.00	272,160,963.16
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	272,171,500.00	272,160,963.16
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЭГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	272,081,100.00	272,070,563.16
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	156,630,700.00	156,620,163.16
210101	Үндсэн цалин	131,971,900.00	131,971,899.79
210102	Нэмэгдэл	9,688,000.00	9,688,000.00
210104	Урамшуулал	14,970,800.00	14,960,263.37
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,451,300.00	19,451,300.00
210201	Тэтгэврийн даатгал	13,588,400.00	13,588,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,465,700.00	1,465,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,172,600.00	1,172,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	293,100.00	293,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,931,500.00	2,931,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44,008,200.00	44,008,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3,299,400.00	2,937,026.50
210302	Түлш, халаалт	33,976,800.00	34,344,277.50
210303	Цэвэр, бохир ус	6,732,000.00	6,726,896.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,622,000.00	3,622,000.00
210401	Бичиг хэрэг	81,300.00	744,000.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,373,100.00	775,075.00

**Баянхонгор сумын 9-р цэцрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210404	Ном, хэвлэл	45,200.00	45,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,602,400.00	1,537,725.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38,354,300.00</b>	<b>38,354,300.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,200.00	42,200.00
210502	Хоол, хүнс	37,907,000.00	37,907,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	405,100.00	405,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,653,600.00</b>	<b>6,653,600.00</b>
210602	Тавилга	3,715,000.00	3,715,000.00
210604	Урсгал засвар	2,938,600.00	2,938,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,300.00</b>	<b>84,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,300.00	84,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>984,800.00</b>	<b>984,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	734,800.00	734,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,291,900.00</b>	<b>2,291,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,291,900.00	2,291,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>90,400.00</b>	<b>90,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>90,400.00</b>	<b>90,400.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,400.00	90,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>272,171,500.00</b>	<b>272,160,963.16</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>225,363,300.00</b>	<b>225,352,763.16</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	225,363,300.00	225,352,763.16
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>46,808,200.00</b>	<b>46,808,200.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	46,808,200.00	46,808,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>17.00</b>	<b>17.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	06.00	06.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>120.00</b>	<b>120.00</b>
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>120.00</b>	<b>120.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	120.00	120.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.27

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО: 2020.02.27

ТАЙЛАН БИЧСЭН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО :2020.02.27